

ЗӨВЛӨМЖ

СОНГУУЛИЙН ЗАРДЫН ТАЙЛАНГ ГАРГАХ ЗААВАР ЖУРАМ, МАЯГТ ЗЭРГИЙГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Ардчилсан сонгуулийн нэг гол зарчим нь сонгуульд өрсөлдөж буй улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид тэнцвэртэй бөгөөд тогтвортой эрх зүйн орчинд тэгш гарааны зарчмаар шударга өрсөлдөх боломжтой байх явдал билээ. Сонгуулийн кампанит ажлын зардал зохистой хэмжээнд байснаар тэгш гарааны зарчим хэрэгжих нөхцөл илүү бүрдэх бөгөөд сонгуульд өрсөлдөгч талууд бэл бэнчингээр биш мэдлэг, туршлага, бодлогоор өрсөлдөн, улмаар ардчилсан сонгуулийн үйл явц, үр дүнд чанарын дэвшил гарах бололцоотой. Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэн сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд сонгуулийн хууль тогтоомжид сонгуулийн зардлыг хязгаарлах, шударга өрсөлдөөнийг дэмжих зорилготой өөрчлөлтүүд нэмэгдсээр ирсэн ч бодит байдалд үр дүн нь төдийлөн мэдэгдэхгүй байна. Олон улсын туршлагаас харахад сонгуулийн зардалтай холбоотой хуулийн зохицуулалтууд хэрэгжих гол нөхцөл нь сонгуулийг санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, хяналт тавих явдал байдаг.

2015 онд УИХ-аас баталсан Сонгуулийн тухай хуульд сонгуулийн зардлыг тайлагнах, хяналтыг сайжруулахтай холбоотой хэд хэдэн чухал өөрчлөлт тусгалаа олсон. Тухайлбал, уг хуулиар анх удаа сонгуульд оролцохоор хүсэлт гаргаж буй улс төрийн нам, эвсэл сүүлийн нэг жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан хандивын тайлангаа, нэр дэвшигчдийн хувьд хөрөнгө орлогын мэдүүлгээ Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ)-нд хүлээлгэн өгөх болсон билээ.

Энэ нь сонгуулийн дараа хагас дутуу байдлаар ил болдог байсан сонгуулийн санхүүжилтийн мэдээллийг сонгуулиас өмнө ил тод, хяналттай болгоход чиглэсэн чухал өөрчлөлт болсон. Түүнчлэн дээрх хуулиар СЕХ-ны оронд Төрийн аудитын байгууллага сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайланг хянах үүрэг хүлээх болсон ба энэ үүргээ хэрэгжүүлэхдээ Татварын асуулдал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтарч ажиллах бололцоотой байдлаар хуульчилж өгчээ.

2016 онд болж өнгөрсөн УИХ-ын сонгууль нь Сонгуулийн тухай шинэ хуулийн хэрэгжилтийг бодит байдалд шалгасан нэг ёсны чухал сорил байв. Сорилтын дүн харин төдийлөн сайн байгаагүйг дээрх сонгуулийн үеэр сонгуулийн санхүүжилтийн ил тод байдалд мониторинг хийсэн иргэний нийгмийн байгууллагуудын тайланд дурдсан дүгнэлтээс үзэхэд тодорхой байна. Тэдний дүгнэснээр хуулийн хэрэгжилт маш хангалтгүй байсан ба сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, хяналт өмнөхөөс сайжраагүй байна. Тухайлбал, мониторингийн тайланд дурдсанаар “Хуульд сонгуулиас хойш 4 сар орчмын дараа нам, эвсэл, нэр дэвшигчдийн санхүүжилтийн мэдээллийг ил болгохоор зохицуулсан. Гэвч энэ нь цаг хугацааны хувьд хожуу байгаагийн зэрэгцээ Төрийн аудитын байгууллагаас олон нийтэд ил болгож буй мэдээлэл нь хяналтын зорилгоор ашиглахад хангалтгүй, ач холбогдол багатай тойм төдий тоо, баримт агуулсан байв” гэжээ.

2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, хяналттай холбоотой зохицуулалтыг цаашид нарийвчлан, боловсронгуй болгох шаардлагатай нь тодорхой боловч уг хуулийг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй агуулгаар нь хэрэгжилтийг нь сайжруулж чадвал нь сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахад дорвитой ахиц дэвшил гарах бололцоотой юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн сунгаа ид өрнөж буй энэ өдрүүдэд 2016 оны УИХ-ын сонгуулийг шинэ хуулиар зохион байгуулсан туршлагаас суралцан сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлж хуулийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах бололцоо нээгдэж байна. Тухайлбал, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд туссан тоо, мэдээлэл үнэн зөв, алдаа мадаггүй эсэхэд хяналт тавих тогтолцоог жинхэнэ утгаар нь бүрэлдүүлж, практик болгож хэвшүүлэхэд сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих үүрэг хүлээсэн төрийн байгууллага буюу


төрийн аудитын байгууллагын идэвх оролцоо чухал гэж үзэж байна. Үүнд юуны өмнө хуулийг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар ойлгомжтой тайлбарласан заавар журам, тайлангийн маягтуудыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

2016 оны УИХ-ын сонгуулийн хувьд сонгуулийн зардлын дансанд орж ирсэн орлогыг холбогдох талууд хэрхэн бүртгэж тайлагнах, зарцуулалтыг хуульд заасан дагуу зарлагын ангилал, гүйлгээ тус бүрээр чухам яаж тайлагнах талаар тодорхой заавар журам байгаагүй. Үүнтэй холбоотой нам, эвсэл, нэр дэвшигчид тайлангаа гаргахдаа СЕХ-ноос жишээ болгон гаргасан нарийвчлал багатай, хяналт тавих боломжгүй тойм дүн шаардсан загвараар тайлангаа гаргасан байдаг. Үүнийг 2016 оны УИХ-д сонгуульд оролцож өрсөлдсөн нэр дэвшигчийн төрийн аудитын байгууллагад хүлээлгэн өгсөн тайлангийн доор үзүүлсэн жишээнээс тодорхой харж болно.

1 Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр
2 Тойргийн дугаар
3 Нэр дэвшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр
4 Тайлан гаргасан огноо

Монгол Ардын Нам
60
2016 оны 7 дугаар сарын 19

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн		Бүгд	Аудитлагдсан
		Мөнгөн дүн	Мөнгөн бүс		
Орлого	1 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө			-	
	2 Хуулийн этгээдээс өгсөн хандив	90,400,000	-	90,400,000	90,400,000
	3 Иргэдээс өгсөн хандив	63,600,000	3,500,000	67,100,000	67,100,000
	4 Нам, Хамтарсан нам, эвслээс оруулсан орлого			-	
ОРЛОГЫН ДҮН		154,000,000	3,500,000	157,500,000	157,500,000
Зардал	1 Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал	43,875,670		43,875,670	43,875,670
	2 Нам, Эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах зардал	76,285,100		76,285,100	76,285,100
	3 Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал		3,500,000	3,500,000	3,500,000
	4 Бичиг хэргийн зардал	545,800		545,800	545,800
	5 Шуудан холбооны зардал	154,000		154,000	154,000
	6 Унааны зардал	2,004,000		2,004,000	2,004,000
	7 Албан томилолтын зардал			-	
	8 Хөлс, урамшууллын зардал	31,063,000		31,063,000	31,063,000
ЗАРДЛЫН ДҮН		153,927,570	3,500,000	157,427,570	157,427,570
ҮЛДЭГДЭЛ		72,431	-	72,431	72,431.00

АУДИТОР 

Дээрх жишээнээс үзэхэд зардлын дансны гүйлгээг ангилсан байдал нь давхцаж болохоор харагдаж байгаа ба ямар гүйлгээг аль бүлэгт багтааж тайлагнахыг тайлбарласан заавар огт байхгүй байсан нь сонгуульд оролцогч талуудын хувьд ойлгомжгүй байдал үүсгэсэн байж болох юм. Жишээлбэл, нэр дэвшигч сонгуулийн кампанит ажлынхаа нээлтийг хийж мөрийн хөтөлбөрөө танилцуулахаар тойргийнхоо сонгогчидтой

уулзалт зохион байгуулсан бол тухайн уулзалтыг “уулзалт, хурал, цуглаан” гэсэн бүлэгт оруулж тайлагнах уу, эсвэл мөрийн хөтөлбөр таниулах гэх үү, “нэр дэвшигчийг сурталчлах” ажиллагааны зардал гэж тайлагнах уу гэсэн асуултын хариу огт тодорхойгүй байна. Нэр дэвшигчдийн хувьд өөрсдийн ойлгосон байдлаар зардлын дансны гүйлгээгээ ангилан тайлбарлах байдал ч ажиглагдсан.

		Мөнгөн дүн	Мөнгө
Зардал	4 Нам, хамтарсан нам, эвслээ оруулсан орлого	100,000,000	
	ОРЛОГЫН ДҮН		
	1 Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал	100,000,000	
	2 Нам, эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах зардал	15,200,000	
	3 Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал	41,500,000	
	4 Бичиг хэргийн зардал	6,956,000	
	5 Шуудан холбооны зардал	620,500	
	6 Унааны зардал	23,500	
	7 Албан томилолтын зардал	35,700,000	
8 Хөлс, урамшууллын зардал			
ЗАРДЛЫН ДҮН			
ҮЛДЭГДЭЛ		100,000,000	

		Хөрөнгөөс				
Хөрөнгөөс	3 Хуулийн этгэдийн өгсөн хандив	40,000,000.00		40,000,000.00		
	4 Иргэдийн өгсөн хандив	4,100,000.00	2,000,000.00	4,100,000.00	2,000,000.00	
	5 Бусад					
	ОРЛОГЫН ДҮН		101,120,000.00	2,000,000.00	101,120,000.00	2,000,000.00
	1 Нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах	38,155,556.00		38,155,556.00		
2 Нэр дэвшигчийг сурталчлах	18,468,725.00	2,000,000.00	18,468,725.00	2,000,000.00		
3 Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах	23,600,000.00		23,600,000.00			
4 Нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхлэсэн байгууллага, түүний ажилтан, шадар туслахын ажлын хөлс, урамшуулал						
5 Бичиг хэргийн зардал	603,800.00		603,800.00			
6 Шуудан, холбооны зардал						
7 Шатахуун, унааны зардал						
8 Штабын зардал						
9 Бусад зардал						
ЗАРДЛЫН ДҮН		80,828,081.00	2,000,000.00	80,828,081.00	2,000,000.00	
Өглөг						
Үлдэгдэл		20,291,919.00		20,291,919.00		

Түүнчлэн зардлын тайланд хавсаргасан дансны гүйлгээний утгаас ч сонгуулийн зорилгоор хуримтлуулсан хөрөнгийг чухам юунд зарцуулж

байгааг харж хянах боломжгүй болохыг 2016 оны сонгуульд оролцсон өөр нэг нэр дэвшигчийн доорх жишээнээс харна уу.

КАПИТРОН БАНК

Депозит дансны хуулга
Хяналтын өглөх эжилтан баталгаажуулснаар хүчинтэй

герCDPReport1214
3053013193 (MNT) - 21110099 ХАНДИВЫН ТҮР ДАНС
(93053003317)

Хуудас 1-1
Огноо 2016.06.05 - 2016.05.13
Өгч үлд 0.00

Ж.№	Г.код	Теллер	Харьцсан данс	Орлого	Зарлага	Үлдэгдэл	Гүйлгээний утга
08	6003017051	1010 3008 - 10443	BA-3099001531010001	39,000,000.00	3,475,000.00	139,000,000.00	Бат-Эрдэнэ-с орлого
09	5004017099	1023 3008 - 10292			126,525,000.00	135,525,000.00	Д.Бат-Эрдэнэ-с 25 шилжүүлсэн мөнх үнэ 3053-3053013193-Т
09	6004017216	1020 3008 - 10292			9,000,000.00		0.00 Д.Эрдэнэбаяр ХБ58121015 итгэмжлэгч Соёлолдог огноо
13	6008048039	1020 3017 - 10390					0.00 Зарлага Эрдэнэбаяр Итгэмжлэгч ХБ58121015
Дүн				139,000,000.00	139,000,000.00		Өгч үлд: 0.00

КАПИТРОН БАНК
АХЛЫН ЭЖИЛТЭН 139

Дээрх нэр дэвшигчийн хувьд 2016 оны 6 дугаар сарын 9-нд зардлын дансандаа өөрийн нэрээр 139,000,000 төгрөг шилжүүлсэн байх агаад сонгуулийн кампанит ажил өрнөсөн 17 хоногийн

хугацаанд ердөө 3 удаа гүйлгээ хийж дээрх мөнгийг зарцуулж дууссан атал юунд чухам зарцуулсныг дансны хуулганаас мэдэх боломжгүй байх аж.

Дээрх гүйлгээний хуулбарт туссан мэдээллийг сийрүүлбэл:

Огноо	Шилжүүлсэн дүн	Зориулалт/тайлбар
2016/6/9	3,475, 000	Модем
2016/6/9	126,525,000	Хувь хүнд шилжүүлсэн, зориулалт тодорхойгүй.
2016/6/13	9,000,000	Өмнөх шилжүүлэг хийсэн хувь хүний данс руу дахин энэ шилжүүлэг хийгдсэн, зориулалт тодорхойгүй.

Тайланд туссан зардлын дансны орлогын мэдээллийг үзэхэд мөн ойлгомжгүй зүйл олон харагдана.


№	Үзүүлэлт	Мөнгөн дүн		Бүрд	Аудитлагдсан
		Мөнгөн дүн	Мөнгөн бус		
Орлого	1 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө			-	
	2 Хуулийн этгээдээс өгсөн хандив	90,400,000	-	90,400,000	90,400,000
	3 Иргэдээс өгсөн хандив	63,600,000	3,500,000	67,100,000	67,100,000
	4 Нам, Хамтарсан нам, эвслээс оруулсан орлого			-	
	ОРЛОГЫН ДҮН	154,000,000	3,500,000	157,500,000	157,500,000

Дээр үзүүлсэн жишээнд нэр дэвшигч мөнгөн бус орлогоо мөнгөн дүнд шилжүүлж тайлагнасан байх авч энэ нь ямар төрлийн бараа, үйлчилгээ байсан, бодитой үнэлгээ мөн эсэх нь мөн л тодорхойгүй байна. Хуульд заасны дагуу мөнгөн бус хэлбэрийн хандивыг зөвхөн нэр дэвшигчид өгч болох ба энэ тохиолдолд заавал гэрээ хийхээр зохицуулагдсан. Гэрээ хийсэн тохиолдолд тайлангийн дээрх хэсгийг магадлан хянах бололцоотой ч 2016 оны УИХ-ын сонгуулийн жишээнээс харахад зардлын тайландаа гэрээ болон бусад санхүүгийн баримт нотолгоо хавсарган ирүүлсэн нэр дэвшигч байгаагүй. Энэ нь бас л анхнаасаа заавар, журам дутмаг байсантай холбоотой гэж үзэж байна. Гэтэл бусад улс орны туршлагыг харахад мөнгөн бус хандивын үнэлгээг хэрхэн хийх, яаж тайлагнах талаар маш нарийн журам гарган мөрдүүлж буй жишээ олон байна. Тухайлбал, АНУ-ын Холбооны Сонгуулийн Хорооноос нэр дэвшигчдэд зориулан гаргасан гарын авлагад мөнгөн бус хандивыг хэрхэн тайлагнах талаар тусгайлан бүлэг гаргаж холбогдох маягтыг хэрхэн бөглөх талаар тодорхой заавар багтаасан байв.

Эдгээр жишээнээс харахад 2016 оны УИХ-ын сонгуулийн сонгуульд оролцогч талуудын гаргаж тайлагнасан зардлыг тайлангаас хангалттай мэдээлэл авч хяналт тавихад бэрхшээлтэй байгаа ба үүнд хуулийг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх буюу зарлагын ангилал, гүйцэтгэл гэдгийг юу гэж ойлгох, улмаар зардлаа хэрхэн тодорхой баримттайгаар тайлагнах талаар цэгцтэй заавар, журам дутмаг байсан нь нөлөөлсөн гэж дүгнэж байна.

Бусад улс орны туршлагыг харахад хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах үүднээс сонгуульд оролцогч талууд орлого, зарлагаа нэг бүрчлэн тайлагнах маягтууд гаргаж, тэдгээрийг хэрхэн бөглөх талаар дэлгэрэнгүй зааврыг гарын авлага, цахим сургалт хэлбэрээр хангалттай өгдөг сайн туршлага олон байна.

Нэр дэвшигчдэд зориулсан Канадын гарын авлагад нэр дэвшигчээр бүртгүүлэхээс эхлээд хандив гэж юуг ойлгох, хэрхэн тайлагнах, зардлын дансанд хуримтлуулсан хөрөнгийг хэрхэн зарцуулах, тайлагнах талаар жишээнд тулгуурлан дэлгэрэнгүй зааж тайлбарласан байна.



Political Financing Handbook for Candidates and Official Agents

Accounting and paying the candidate's personal expenses	63
Dividends	75
Property or services provided by the party or the registered association	79
Claims and loans repayment	82
Administering the candidate's personal expenses	79
Supporting documentation	71
REPORTING REQUIREMENTS	73
4.1 Reporting timeline	74
Returning tax receipts	75
4.2 Mandatory documents and supporting documentation	76
Documents to be filed within four months after election day	76
Candidate's Election Campaign Return	76
Candidate's Statement of Personal Expenses	77
Auditor's Report	77
Candidate's Statement of Gifts or Other Advantages Received	78
Reporting payment of claims or loans	78
Update after final payment of claims or loans within 36 months after election day	78
Candidate's Statement of Unpaid Claims and Loans 18 or 36 Months After Election Day	78
Update after final payment of claims or loans more than 36 months after election day	79
4.3 Submission to Elections Canada	80
Filing deadline and electronic	80
Documents not eligible for extension	81
Court extension	82
Consequences of late filing	82
CLOSING THE CANDIDATE'S CAMPAIGN	83
5.1 Repatriation of funds administered by Elections Canada	84
Returning tax receipts	84
IRS mailbox waiver	84
Reimbursements	85
What is reimbursable	85
How the reimbursement is calculated	85
Reduction of reimbursement amount	85
How the reimbursement is paid	85
Returning contributions	85
Additional payments	85
Auditor's subsidy	85
How the subsidy is calculated	85
5.2 Managing unpaid claims and loans	88
Authorization to pay claims or loans after 36 months	88
5.3 Filing an amended candidate's return	89
Conditions or receipts required by Elections Canada	89
Conditions or receipts required by the candidate or the official agent	89
5.4 Disposing of surplus	90
Definition	90

Table of contents

ARREST BY ENDOCKUMENT	9
Conduct information	18
TABLES AND REMINDERS	11
Important deadlines for the candidate's campaign	11
Limits on cash, donations, loans and loan guarantees	12
Transfers - types and rules	14
Reporting requirements for the candidate's campaign	15
Important reminders for candidates and their official agents	16
Filing deadline summaries	18
STARTING THE CANDIDATE'S CAMPAIGN	19
1.1 How to become a candidate	19
Definition	19
Eligibility	20
Substantive process	21
The candidate's responsibilities and obligations	21
1.2 What has to be done at the beginning of the campaign	23
Appoint an official agent	23
Definition	23
Eligibility	24
Appointments process	24
The official agent's responsibilities and obligations	24
Appoint an auditor	25
Definition	25
Appointments process	25
The auditor's responsibilities and obligations	25
Open a bank account	26
Establishing internal controls	26
Other on a campaign start ensuring success in accepting contributions, loans or services	27
CAMPAIGN IMPROVEMENTS	29
Introduction	29
2.1 Contributions	31
Definition	31
What is a contribution?	31
When are candidates?	31
Mandatory contributions	31
Non-mandatory contributions	31
What is a non-mandatory contribution?	32
Volunteer labour	32
2.2 Loans	33

Канад, Австрали, АНУ гэх мэт улсуудын хувьд сонгуулийн санхүүжилтэд сонирхсон талууд хөндлөнгөөс хяналт тавих бололцоо олгон орлогыг хандивлагч тус бүрээр, зарлагыг гүйлгээ

тус бүрээр тайлбартайгаар тайлагнаж байна. Манайд ч мөн ийм байдлаар сонгуульд оролцогч талууд зардлаа тайлагнаж эхэлбэл хяналт тавихад дөхөмтэй болох юм.

Канадын Ерөнхий Сайд Жастин Трудиоогийн сонгуулийн санхүүжилтийн тайлангаас

No.	Name of contributor	Address	Date received	Monetary \$	Non-monetary \$	Amount of monetary and non-monetary contributions \$
1	TERENCE H MATTHEWS	KANATA ON K2K2X3	Sep 14, 2015	700.00	0.00	700.00
Total contributions greater than \$200 \$				700.00	0.00	700.00
Total contributions of \$200 or less \$				0.00	0.00	0.00
Total number of contributors of amounts of \$200 or less				0	0	0
Total anonymous contributions of \$20 or less \$				0.00	0.00	0.00
Total number of anonymous contributors of amounts of \$20 or less				0	0	0
Total contributions \$				700.00	0.00	700.00
Total number of contributors						1

No.	Date	Supplier	Description	Cheque no.	Amount paid \$	Contributed or transferred property or service \$	Unpaid claim \$	1 Advertising \$	2 Voter contact calling services \$	3 Office \$	4 Salaries and wages \$	5 Other \$
12	Aug 24, 2015	4307267 CANADA INC	Signs (lawn signs, billboards, other)	000004	804.83	0.00	0.00	804.83	0.00	0.00	0.00	0.00
11	Aug 24, 2015	4307267 CANADA INC	Signs (lawn signs, billboards, other)	000002	1,609.65	0.00	0.00	1,609.65	0.00	0.00	0.00	0.00
10	Aug 24, 2015	4307267 CANADA INC	Signs (lawn signs, billboards, other)	000003	1,609.65	0.00	0.00	1,609.65	0.00	0.00	0.00	0.00
134	Dec 14, 2015	A VOZ DE PORTUGAL	Print media (newspapers, magazines, other)	000126	443.48	0.00	0.00	443.48	0.00	0.00	0.00	0.00
6	Aug 15, 2015	ALF - PAPINEAU	VARIOUS	000082	19,099.34	0.00	0.00	689.85	0.00	17,884.59	0.00	524.90

Олон улсын туршлагыг харахад бодитой хяналт тавих бололцоотой байдлаар тайланг гаргахад дараах наад захын мэдээллийг тусгах шаардлагатай гэж үздэг байна. Үүнд:

Орлогын мэдээлэл	Зарлага
<ul style="list-style-type: none"> - Эх үүсвэр /өөрийн хөрөнгө, намаас дэмжлэг, хандив/ - Хаяг* - Ажлын газар буюу ажил олгогчийн нэр - Мэргэжил/албан тушаал - Хандив хүлээн авсан огноо - Хандивын хэмжээ 	<ul style="list-style-type: none"> - Төлбөр хүлээн авсан байгууллагын нэр - Хаяг - Тухайн гүйлгээгээр чухам ямар төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан талаар тайлбар - Огноо - Нийт төлбөрийн хэмжээ

Ийнхүү нарийвчлалтай тайлагнахаас гадна хууль хяналтын байгууллагад ирсэн санхүүжилтийн мэдээллийг шуурхай ил тод болгож иргэд хяналтаа тавих бололцоог давхар олгож байна.

АНУ-д нэр дэвшигч санал хураах өдөр хүртэлх 20 хоногийн хугацаанд 1000 болон түүнээс дээш долларын хандив хүлээн авснаа 48 цагийн дотор тайлагнасан жишээ:

48-HOUR NOTICE OF CONTRIBUTIONS/LOANS RECEIVED

(See Reverse Side for Instructions)

16 OCT 31 PM 4:43

To be used to report all contributions (including loans) of \$1000 or more, received within 20 days of the election.

1. NAME OF COMMITTEE IN FULL Lisa Murkowski for U.S. Senate			
ADDRESS (number and street), P.O. Box, 100847			
CITY Anchorage	STATE AK	ZIP CODE 99510	
2. NAME OF CANDIDATE Murkowski, Lisa, . . .		3. OFFICE SOUGHT (State and District) Senate AK	4. FEC IDENTIFICATION NUMBER .C00384529
5. IS THIS AN AMENDMENT? <input checked="" type="checkbox"/> NO, THIS IS A NEW FILING <input type="checkbox"/> YES, IT AMENDS THE NOTICE FILED ON _____ / _____ / _____			
A. FULL NAME Dobb, Bryan, . . .			
MAILING ADDRESS 2132 Benson Rd		Name of Employer MAC Pizza LLC	Date (month, day, year) 10/29/2016
CITY Point Roberts	STATE WA	ZIP CODE 98281-9203	Amount 1000.00
Transaction ID : 6802CAE2F038A4194		Occupation Partner	
B. FULL NAME Hall, Cecily, . . .			
MAILING ADDRESS 3429 260th Ave NE		Name of Employer Premiera Blue Cross	Date (month, day, year) 10/29/2016
CITY Redmond	STATE WA	ZIP CODE 98053-3000	Amount 1000.00
Transaction ID - 632C97D92D869410C		Occupation Senior Vice President	
C. FULL NAME Ashlock, Hugh, . . .			
MAILING ADDRESS 3822 Lockmoor Dr.		Name of Employer Jblako Investments Inc.	Date (month, day, year) 10/29/2016
CITY Anchorage	STATE AK	ZIP CODE 99508-5022	Amount 2700.00
Transaction ID : 6D74F900CAFE545B		Occupation Vice-President	
D. FULL NAME			
MAILING ADDRESS		Name of Employer	Date (month, day, year)
			Amount

Нэр дэвшигчийн мэдээлэл

Хандивлагчийн нэр

Хандивлагчийн ажил олгогчийн нэр

Хандивын хэмжээ

Хандив хүлээн авсан огноо

Хандивлагчийн хаяг

Энэ дашрамд дурдахад дээрх бүх мэдээллийг хүссэн хүн үзэх боломжтой байдлаар холбогдох хууль хяналтын байгууллагууд нь цахим хуудсандаа байруулсан байна.

Цаашид сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, түүнд тавих хяналтын сайжруулахад төрийн аудитын байгууллагын зүгээс идэвх санаачлага гарган, сонгуулийн тухай хуулийн

холбогдох заалтуудыг сонгуульд оролцогч талууд хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар ойлгомжтой тайлбарласан заавар журам, тайлангийн маягтуудыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна гэж найдаж байна.